

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Хүүхдэд хамгааллын бодлогын хэрэгжилтийн тайлан, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалгүйгээс нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцож үнэлээгүй байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын тайлан

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/20-ШТА-ГА

Чойбалсан хот
2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
Аудитор М.Ганбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ganbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
Хүснэгтийн товъёг.....	5

БҮЛЭГ 1. ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР УРТ, ДУНД, БОГИНО ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ЗААСАН АРГА ХЭМЖЭЭ БҮРЭН ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.....6

1.1.1 Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан бодлогын баримт бичиг хоорондын уялдаа хангагдсан байна.....6

1.1.2 Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан бодлогын баримт бичигт заасан арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна.....6

1.2.1 ХГБХХГ, сум, багийн өрхийн эмч, цагдаа хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж, гэр бүл дэх хүүхдийн хүчирхийллийн тоо буурахгүй байна.....7

1.2.2 Хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагааны мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүйгээс хүүхдийн эрх хамгийн их зөрчигдөж байгаа асуудалд бодлого боловсруулахад хүндрэл гарах эрсдэлтэй байна.....8

1.2.3 ХГБХХГ-т хүүхэд хамгааллын мэргэжилтний орон тоо хүрэлцээгүй, мэргэшсэн албан хаагч цөөн, хамтарсан багийн нийгмийн ажилтнууд нь мэргэжлийн шаардлагыг хангахгүй байна.....8

БҮЛЭГ 2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД ШААРДЛАГАТАЙ НӨӨЦИЙГ ОНОВЧТОЙ ТОДОРХОЙЛЖ, ЗАРДЛЫГ ХУВААРИЛААГҮЙ БАЙНА.....9

2.1.1 Хүүхэд хамгаалалд зориулсан төсөв, зардлыг судалгаанд үндэслэн тооцож төлөвлөөгүй байна.....9

2.1.2 Хүүхэд хамгааллын төсөв хөрөнгө нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон хүүхдийн эрхийн шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглээгүй байна.....9

2.1.3 Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай нөөцийг оновчтой тодорхойлж, зардлыг хуваарилж чадахгүй байна.....10

2.2.1 Улсын төсвөөс хуваарилагдаж ирсэн хүүхэд хамгааллын зардлыг урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд зарцуулсан байна.....10

2.2.2 Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалттай холбоотой мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй байна.....11

2.2.3 Хүүхэд хамгааллын талаар олон улсын донор байгууллагын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалтад хяналт хийсэн тухай баримт, тайлан, мэдээлэл орон нутагт байхгүй байна.....11

2.2.4 Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр нь бүх талыг хамраагүй байна.....12-13

2.2.5 Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхдийн хувь хүний нууц алдагдах эрсдэл өндөр байна....14

2.2.6 Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг 2022 оноос урьдчилсан сэргийлэх ажил болон хариу үйлчилгээнд хуваарилж төсөвлөсөн байна.....15

БҮЛЭГ 3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНГ ҮНЭЛЭЭГҮЙГЭЭС НИЙГЭМД ГАРЧ БУЙ ЭЕРЭГ НӨЛӨӨГ ТООЦОХГҮЙ БАЙНА..... 15

3.1.1 Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлалгүйгээс хийгдсэн ажлын үр нөлөөг үнэлдэггүй байна.....15

3.1.2 Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хуулийн хэрэгжилтийн талаарх судалгаа, хяналт шинжилгээ хангалттай хийгдээгүйгээс сайжруулах шаардлагатай хэсгийг тодорхойлж ажиллаагүй байна.....	15
3.1.3 Олон Улсын байгууллагаас Засгийн газарт өгсөн зөвлөмжийг биелүүлдэггүйгээс хүүхэд хамгаалал хангалттай сайжрахгүй байх эрсдэл нөхцөлийг бий болгосон байна.....	16
3.1.4 Хүүхэд хамгааллын чиглэлээр Олон Улсын байгууллагаас хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнг тооцоогүйгээс хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээлэл гарахгүй байна.....	17
3.1.5 Бодлогын хэрэгжилтийг бодитой үнэлж тайлагнадаггүйгээс бодлого нь нийгэмд ямар үр нөлөө бий болгосныг тооцоогүй байна.....	17
3.1.6 Хүүхдэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалгүйгээс хэрэгжилт, үр нөлөөг үнэлээгүй байна.....	17
3.1.7 Хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлснээр нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцож үнэлдэггүйгээс бодлогын үр нөлөөг тооцоолдоггүй байна.....	18
3.2.1 Гэр бүлийн орчинд чиглэсэн урьдчилсан сэргийлэх арга хэмжээ, үйлчилгээ хангалтгүйгээс гэр бүлийн орчин дахь хүүхдийн хүчирхийллийн тоон үзүүлэлт буурахгүй байна.....	18
3.2.2 Боловсролын байгууллагууд хүүхэд хамгааллын бодлогыг үйл ажиллагаандаа баримтлан ажилласан байна.....	19
3.2.3 Эрүүл мэндийн байгууллага нь төрийн бус байгууллагатай хамтарч хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж ажилласан байна.....	19
3.2.4 Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалал хангагдахгүй байна.....	20
3.2.5 Олон нийтийн арга хэмжээ, соёл, спортын үйл ажиллагаанд хүүхэд хамгааллыг хангаж ажилласан байна.....	21
3.2.6 Аймгийн “Хүүхэд хамгааллын бодлого”-ын баримт бичигт гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгааллын асуудлыг тусгаагүй байна.....	22
3.3.1 Монгол Улс Хүүхдийн эрхийн олон улсын конвенцод нэгдсэн үүргийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл орон нутагт байхгүй байна.....	22
3.3.2 Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, мөшгөх судалгаа хийгээгүй байна.....	22-23
3.3.3 Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээг стандартад заасан хугацаанд түргэн шуурхай хүргээгүй байна.....	24
3.3.4 Аймгийн Цагдаагийн газраас хүүхдийн эсрэг гэмт хэргийн суурь шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллаж байгаа ч хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоо буурахгүй байна.....	24
3.3.5 Хүүхэд хамгаалалтай холбоотой хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн хүчирхийллийн тоон үзүүлэлт дээр дүн шинжилгээ хийж, шалтгааныг тогтоож ажиллахгүй байна.....	25
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....	25
ДҮГНЭЛТ:	26
САНАЛ:	27
ЗӨВЛӨМЖ:	28
АЛБАН ШААРДЛАГА.....	29-30
ТУШААЛ.....	31-32

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын стандарт
ЗГ	Засгийн газар
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ХГБХХЕГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар
ХГБХХГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
MNS	Mongolian national standard
ХШҮ	Хяналт шинжилгээ үнэлгээ
ТББ	Төрийн бус байгууллага

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Монгол Улсын хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан арга хэмжээ	5
Хүснэгт 2	Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тоо мэдээлэл	8
Хүснэгт 3	Хүүхэд хамгааллын зардлын ангилал	9
Хүснэгт 4	Урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд хамрагдсан хүүхдийн тоо	11
Хүснэгт 5	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд болон хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо мэдээлэл	12
Хүснэгт 6	Бэлгийн хүчирхийлэлд өрсөн хүүхдийн тоо	13
Хүснэгт 7	Соёл, спортын арга хэмжээнд хамрагдсан хүүхдийн тоо	19
Хүснэгт 8	Хүүхдийн тусламж 108 утсанд ирсэн дуудлагын жагсаалт	21
Хүснэгт 9	Хэрлэн сумын 11 дүгээр багт хүүхдийн тусламжийн 108 дугаар ирсэн дуудлагын жагсаалт	21

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 ¹ , 6.3.3 ² , 7 дугаар зүйлийн 7.1.2 ³ , 7.2 ⁴ дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн гүйцэтгэсэн.
Аудитын зорилт	Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт болон бий болсон үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан Үндэсний аудитын газар, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх; • Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх; • Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаанд оролцдог төрийн болон төрийн бус байгууллагуудын 2019-2023 оны үйл ажиллагаа, баримт, тайлан, мэдээллийг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 200, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер И.Сэмжидмаа аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, аудитор М.Ухаанбилэг, М.Ганбилэг нар дэд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ. Аудитын дэд төлөвлөгөөг 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр батлуулж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 10 дугаар сарын 23-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж хэлэлцүүлэн, тайланг 10 дугаар сарын 25-нд Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

¹ шалгагдагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;² төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд хуульд заасан болон шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар аудит хийх;³ гүйцэтгэлийн аудит;⁴ Төрийн аудитын байгууллага энэ хуулийн 7.1-д заасан аудитыг нэгдсэн, хамтарсан, зэрэгцээ, баталгаажуулах, мэдээллийн технологийн болон бусад хэлбэрээр хийж болно.

БҮЛЭГ 1. ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР УРТ, ДУНД, БОГИНО ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ЗААСАН АРГА ХЭМЖЭЭ БҮРЭН ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

1.1.1 Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан бодлогын баримт бичиг хоорондын уялдаа хангагдсан байна.

Аймгийн Засаг даргын 2015 оны А/288 дугаар захирамжаар “Хүүхэд хамгааллын бодлого”-ын баримт бичгийг баталсан байна. Аймгийн “Хүүхэд хамгааллын бодлого”-ын баримт бичиг нь нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг аливаа хэлбэрийн эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн.

Аймгийн “Хүүхэд хамгааллын бодлого”-ын баримт бичгийг хүүхэд, гэр бүлтэй ажилладаг байгууллага бүр үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг орон нутагт хүүхэд, гэр бүлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудад үүрэг болгосон байна.

Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Дорнод аймгийг 2021-2025 хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 82 дугаар тогтоолоор “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлж байна.

Аймгийн хүүхэд хамгааллын бодлоготой уялдуулж “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийг 2021-2024 он хүртэл дараах 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөн баталсан байна. Үүнд:

1. Нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг аливаа хэлбэрийн эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлнэ.
2. Хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжүүлэхэд мөрдөгдөж буй стандартыг хэрэгжүүлэх замаар эрүүл аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлнэ.
3. Засаглалын бүх түвшинд хүүхдийг сонсох, үзэл бодлыг хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлж, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэн тэдний оролцоог нэмэгдүүлнэ.
4. Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн чадавхыг бэхжүүлж, салбарын хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

1.1.2 Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан бодлогын баримт бичигт заасан арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна.

Монгол Улсын хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1

Баримт бичгийн нэр	“Алсын хараа-2050” монгол улсын урт	Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны	Дорнод аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл
--------------------	-------------------------------------	---	---

	хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	үйл ажиллагааны хөтөлбөр	ажиллагааны мөрийн хөтөлбөр
Холбогдох зүйл, заалт	9.1.8 Хүүхэд хамгаалах төв , хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр өнжүүлэх төв, асрамжийн газрын хүчин чадлыг нэмэгдүүлж, шаардлагатай тохижилт үйлчилгээг хийнэ.	4.3.3 Эмэгтэйчүүд, хүүхэд , ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байрыг байгуулж , хуульд заасны дагуу мэдээллээр хангана.	2.6.7 Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, иргэдэд нийгмийн хамгаалал, хууль, эрх зүйн дэмжлэг үйлчилгээ үзүүлдэг “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг төвлөрсөн дэд бүтэцтэй байршилд шилжүүлнэ.

Эх сурвалж: *legalinfo.mn* эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем

Аймгийн ХГБХХГ-ын харьяанд үйл ажиллагаа явуулж байгаа хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, хүүхдийн эрхийг хангах түр хамгаалах байр нь “Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 6040:2019 стандарт”-д тусгагдсан заалтуудыг хангахгүй байна.

Дорнод аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, иргэдэд нийгмийн хамгаалал, хууль, эрх зүйн дэмжлэг үйлчилгээ үзүүлдэг “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг төвлөрсөн дэд бүтэцтэй байршилд шилжүүлнэ гэж тусгасан ч энэ заалт хэрэгжээгүй байна.

Дээрх заалт хэрэгжээгүйгээс хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг стандартын дагуу үзүүлэх нөхцөл бүрдээгүй байна.

1.2.1 ХГБХХГ, сум, багийн өрхийн эмч, цагдаа хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж, гэр бүл дэх хүүхдийн хүчирхийллийн тоо буурахгүй байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаарх мэдээлэл, судалгаанд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлж ажиллаагүй байна.

Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын ерөнхий газарт гаргаж хүргүүлдэг үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны А/145 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”-аар гаргасан мэдээгээр аймгийн хэмжээнд 2021 онд 1489 хүүхэд, 2022 онд 2399 хүүхэд, 2023 онд 7450 хүүхэд эрсдэлт нөхцөлд байна.

Эдгээр эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн мэдээллийн санг бүрдүүлээгүй мөн нөхцөл байдлын үнэлгээ хийгээгүй байна. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоог үнэн зөв тооцож гаргасан эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийхгүй, зөвхөн тохиолдол болсон үед нөхцөл байдлын үнэлгээ хийж хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлж байна.

Дорнод аймгийн хэмжээнд 24 хамтарсан баг байна. Аудитаар 13 багийн үйл ажиллагааг шалгаж, багийн нийгмийн ажилтан, гишүүдтэй уулзалт, ярилцлага

хийхэд багийн өрхийн эмч, цагдаа нь хамтарсан багийнхаа хуралд суудаггүй, хүүхэд хамгааллын дуудлага мэдээлэлд нийгмийн ажилтантай хамт очиж ажиллахгүй тохиолдол цөөнгүй гардаг байна.

1.2.2 Хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагааны мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүйгээс хүүхдийн эрх хамгийн их зөрчигдөж байгаа асуудалд бодлого боловсруулахад хүндрэл гарах эрсдэлтэй байна.

Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын ерөнхий газарт 2019-2023 оны хооронд хүүхэд хамгаалалтай холбоотой мэдээллийг дараах программ, маягтаар гаргаж хүргүүлсэн байна.

Аблэ программ, Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны А/145 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны А/16 дугаар тушаалаар батлагдсан Статистикийн мэдээллийн маягт, маягт нөхөх заавар, Хүүхдийн тусламжийн 108 утасны программ, и-тусламж программ, нийгмийн ажилтны мэдээллийн сан программ, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2018 оны А/202 дугаар тушаалаар батлагдсан Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг тооцох аргачлал, маягт эдгээр программ, маягтын дагуу 2019-2023 онд тайлан мэдээгээ гаргаж ажилласан байна.

Программ болон статистик мэдээний маягтаар гаргасан мэдээллүүд нь хоорондоо зөрүүтэй байна.

Шалтгаан нь мэдээллийг оруулах шалгуур үзүүлэлт харилцан адилгүй байгаатай холбоотой байна. Жишээ нь хурдан морь унаач хүүхдийн тоо нь Able программд бүртгэхдээ хурдан морины уралдаан зохион байгуулагдахад бүртгүүлсэн хүүхдийн тоон мэдээллийг оруулдаг бол Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны А/145 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал”-аар сум нь тухайн суманд амьдарч байгаа хурдан морь унадаг уралдаанч хүүхдийн тоог нэгтгэн гаргадаг байна.

Хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагааны мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй байна. Иймд хамгийн эрсдэлтэй буюу хүүхдийн эрх хамгийн их зөрчигдөж байгаа асуудалд дүн шинжилгээ хийж, бодлого боловсруулахад хүндрэл гарах эрсдэлтэй байна.

1.2.3 ХГБХХГ-т хүүхэд хамгааллын мэргэжилтний орон тоо хүрэлцээгүй, мэргэшсэн албан хаагч цөөн, хамтарсан багийн нийгмийн ажилтнууд нь мэргэжлийн шаардлагыг хангахгүй байна.

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар 2023 онд батлагдсан төлөвлөгөөний дагуу 21 орон тоогоороо бүрэн ажилласан байна. Үүнээс нийгмийн ажилтан 3, сэтгэл зүйч 2 байна. Аймгийн хэмжээгээр 31663 хүүхдэд 1 хүүхдийн эрхийн байцаагч, 1 хүүхэд хамгааллын мэргэжилтэн ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харьцах, дохионы хэл эзэмшсэн мэргэжилтэн байхгүй байна.

Хүүхдийн эрхийн байцаагч, хүүхэд хамгааллын мэргэжилтэн аймаг, сум, багийн хэмжээнд хэдэн хүүхдэд хүрч ажиллах тухай тогтоосон стандарт, журам, заавар байхгүй байна.

Хүүхэд хамгааллын 24 хамтарсан багийн нийгмийн ажилтнуудын 67 хувь нь буюу 16 нь нийгмийн ажилтны мэргэжил эзэмшээгүй эрх зүйч, нягтлан бодогч, газар зохион байгуулалт зэрэг мэргэжилтэй байна.

Энэ нь нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 6949:2021 стандартын “6.2.1 Нийгмийн ажилтан нь магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн нийгмийн ажлын бакалавр, магистр, докторын боловсролын зэрэгтэй байна.” гэсэн шаардлагыг хангахгүй байна.

Иймээс дээрх асуудлыг аудитын дунд хугацааны эрсдэлд бүртгэж, “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө”-д хийгдэж буй гүйцэтгэлийн аудитаар шалгуулахаар шилжүүлэв.

БҮЛЭГ 2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД ШААРДЛАГАТАЙ НӨӨЦИЙГ ОНОВЧТОЙ ТОДОРХОЙЛЖ, ЗАРДЛЫГ ХУВААРИЛААГҮЙ БАЙНА.

2.1.1 Хүүхэд хамгаалалд зориулсан төсөв, зардлыг судалгаанд үндэслэн тооцож төлөвлөөгүй байна.

Хүүхэд хамгаалалд зориулсан төсөв, зардлыг сум, багийн түвшинд эрсдэлийн дүн шинжилгээ, судалгаанд үндэслэн тооцож төлөвлөх шаардлагатай ч хүүхэд хамгааллын төсвийн төслийг бэлтгэхдээ өмнөх оны мэдээлэл, төсвийн гүйцэтгэлд үндэслэж боловсруулсан байна.

Энэ нь хүүхэд хамгааллын төсвийн төслийг боловсруулах аргачлал, заавар, журмыг Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын ерөнхий газраас батлан гаргаагүйтэй холбоотой байна.

2.1.2 Хүүхэд хамгааллын төсөв хөрөнгө нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон хүүхдийн эрхийн шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглээгүй байна.

Хүүхэд хамгааллын зардлын 60 хувийг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тоо, мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2

Утга	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Бэлгийн хүчирхийллийн хохирогч	16	15	15	18	22
Гэмт хэргийн хохирогч	61	46	44	56	51
Мориноос унаж, бэртэж гэмтсэн хүүхэд	32	57	38	40	52
	109	118	97	114	125

Эх сурвалж: Аймгийн эрүүл мэндийн газар, цагдаагийн газрын судалгаа.

Хүснэгтээс харахад хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэргийн тоо өссөн байна. Хүүхэд хамгааллын төсвөөс зарцуулсан урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулаагүй байна.

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлд судалгаа хийгдээгүй байна.

2.1.3 Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай нөөцийг оновчтой тодорхойлж, зардлыг хуваарилж чадахгүй байна.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх зардал 2022 онд 3.4 сая төгрөг, 2023 онд 2.4 сая төгрөгийг ХГБХХГ-т улсын төсвөөс олгосон байна. Энэ нь ХГБХХГ-т улсын төсвөөс олгосон хүүхэд хамгааллын нийт зардлын 0.02 хувийг эзэлж байна.

Сум, багийн хүүхэд хамгааллын хамтарсан баг нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг гаргадаг боловч эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд нөхцөл байдлын үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ хийж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.

Сум, багийн хамтарсан багуудад эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд нөхцөл байдлын үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ хийх зардлыг хуваарилж олгоогүй байна.

Дээрхээс дүгнэхэд хүүхэд хамгааллын үйл ажиллагааг анхан шатанд зохион байгуулж буй хүүхэд хамгааллын хамтарсан багт зардал хуваарилж олгоогүй нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд⁵ заагдсан хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх чиг үүргээ хийхгүй байх нөхцөлийг бий болгож байна.

2.2.1 Улсын төсвөөс хуваарилагдаж ирсэн хүүхэд хамгааллын зардлыг урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд зарцуулсан байна.

Улсын төсвөөс хүүхэд хамгааллын зардалд 2019-2021 онд нийт 75.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүүхэд хамгааллын зардлын ангиллыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3 /мянган төгрөгөөр/						
д/д	Зардлын зүйл	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Хүүхэд хамгааллын зардал	14.8	14.6	45.7		
2	Нөхцөл байдлын үнэлгээ хийх				3.4	2.4
	Хамгаалах нөхөн сэргээх				70.9	79.1
	Урьдчилан сэргийлэх				49.7	34.7
	дүн	14.8	14.6	45.7	124.0	116.2

Эх сурвалж: ХГБХХГ-ын 2024.10.04-ны №329 тоотой ирүүлсэн судалгаа.

Хүүхэд хамгааллын зардал нь 2022 оноос хамгаалах нөхөн сэргээх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, урьдчилан сэргийлэх гэсэн зардлын зүйлээр ангилагдаж ирсэн байна.

⁵ 20.2.Хамтарсан баг дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.2.2.хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;

20.2.3.нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх;

Улсын төсвөөс хуваарилагдаж ирсэн хүүхэд хамгааллын зардлыг урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд зарцуулсан байна.

2.2.2 Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалттай холбоотой мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй байна.

Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтын тайлан мэдээг Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын ерөнхий газар хүргүүлж ажилласан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2016 оны А/330 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам”-ын дагуу Дорнод аймагт “Бүхнийг хүүхдийн төлөө” ТББ, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо”, “Аз жаргал төв” гэсэн 3 байгууллага магадлан итгэмжлэгдэж үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр төрийн бус байгууллагатай байгуулсан гэрээ мөн хүүхэд хамгааллын зардлын хөрөнгө зарцуулах тухай байгууллагын даргын 2022 онд А/01 дүгээр тушаалаар 130.4 сая төгрөг, 2023 оны А/13 дугаар тушаалаар 37.8 сая төгрөг, 2023 оны А/14 дүгээр тушаал 79.0 сая төгрөгийн зарцуулах шийдвэрийг байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулж мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн “6.4.8 ..., төр, **хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах**, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д заасны дагуу санхүүжилтээ мэдээлэх үүрэгтэй. “Анна хоме” асрамж, халамжийн төвд 2023 онд нийт 11.0 сая төгрөгийн хувьсах зардлыг олгосон байна. “Анна хоме” асрамж, халамжийн төв нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэсгүйгээс авсан санхүүжилтээ мэдээлээгүй байна.

2.2.3 Хүүхэд хамгааллын талаар олон улсын донор байгууллагын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалтад хяналт хийсэн тухай баримт, тайлан, мэдээлэл орон нутагт байхгүй байна.

Дорнод аймагт Хүүхэд хамгааллын талаар Олон улсын донор байгууллагуудаас дараах тусламжууд олгогдсон байна. Үүнд:

- Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын нэг цэгийн үйлчилгээний төвийн байрыг тохижуулахад Нэгдсэн үндэсний байгууллагын хүн амын сангаас 52,3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, хэрэгслийг тусламжаар олгосон байна.
- Америкийн нэгдсэн улсын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй Дэлхийн зөн Олон улсын байгууллагын “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төсөл Улаанбаатар, Эрдэнэт хот, Дорнод, Дорноговь, Дундговь, Говь-Алтай, Увс зэрэг байгалийн гамшигт өртөмтгий таван аймагт хэрэгжсэн байна. Төслийн хүрээнд “Аврагч мазаалай” сургалтын танхим байгуулагдаж 30.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж олгосон байна.
- Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж байсан Японы хүүхдийг ивээх сангаас 2022 онд өөрсдийн хэрэглэж байсан 10 нэр төрлийн 15 ширхэг 4,0 сая төгрөгийн тоног

төхөөрөмж, тавилгыг Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт шилжүүлсэн байна.

Дээрх олон улсын донор байгууллагын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалтад хяналтыг ЗГ-ын 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-д зааснаар хяналтыг Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хяналт шинжилгээ үнэлгээний ажилтан хийхээр заасан байна.

ЗГ-ын 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 23 дугаар хэсгийн “23.1. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн **ХШҮ-ний ажилтан төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд улирлын давтамжтайгаар хяналт-шинжилгээ хийж, гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Төслийн хяналт-шинжилгээний тайлангийн загвар” маягтын дагуу хяналт-шинжилгээний тайланг боловсруулан Удирдлагын мэдээллийн системд оруулах бөгөөд төслийн удирдах хороонд хагас жил тутам танилцуулна.**”, “23.2. ХШҮ-ний ажлын хэсэг нь төслийн хэрэгжилтийн **явцын үнэлгээг жил бүр дараа жилийн эхний улиралд багтаан хийх** бөгөөд үнэлгээний тайланг гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Төслийн үнэлгээний тайлангийн загвар” маягтын дагуу боловсруулна. Төсөл хэрэгжүүлэх нэгж нь тайланг төслийн удирдах хороонд тухай бүр танилцуулж, холбогдох мэдээлэл, тайланг Удирдлагын мэдээллийн системд оруулна.” гэж заасны дагуу хийсэн ажлын баримт материал орон нутагт байхгүй байна.

2.2.4 Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр нь бүх талыг хамраагүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн “2.2.Хүүхэд хамгаалал нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ.”.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын “4.1.2.”хүүхэд хамгаалал” гэж нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн энэ хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг” гэж заасан байна.

Дорнод аймагт хүүхэд хамгааллын цогц үйлчилгээг үзүүлэхээр 24 хамтарсан багт 148 албан хаагч ажиллаж байна.

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын үйл ажиллагааны тайланд дурдагдсан урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд хамрагдсан хүүхдийн тоо:

Хүснэгт №4

Он	Урьдчилан сэргийлэх		Хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо
	Үйл ажиллагааны тоо	Хамрагдсан хүний тоо	
2019 он	28	11250	123
2020 он	14	13000	170

2021 он	24	16667	257
2022 он	11	4322	519
2023 он	57	25749	830
Нийт	134	70988	1808

Эх сурвалж: ХГБХХГ-ын үйл ажиллагааны тайлан, статистик мэдээ

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд чиглэсэн урьдчилан сэргийлэх үйлчилгээ болох нөлөөллийн арга хэмжээ, олон талт, хамтарсан арга хэмжээнүүдийн үр дүнг тооцох нарийвчилсан аргачлал байхгүй тул хамрагдсан хүүхдийн тоогоор үнэлж тооцсон нь бодит үр дүнг илэрхийлэхгүй байна.

Дорнод аймагт эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо 2019-2023 онуудад 1489-7450 бүртгэгдэж сүүлийн хоёр жил дараалан өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд болон хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5

Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
01-17 нас	29,650	29,931	31,507	31,725	31,663
Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо	2,212	3,200	1,489	2,399	7,450
Эрсдэлийн үнэлгээ хийсэн хүүхдийн тоо	87	34	93	135	163
Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо /давхардсан/	123	170	257	519	830

Эх сурвалж: ХГБХХГ-ын Хүүхдийн статистик мэдээ 2019-2023 он

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо өссөн нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг, хагас өнчин, сургуулийн дотуур байранд байрлан суралцдаг зэрэг хүүхдүүдийг оруулж тооцсонтой холбоотой байна. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд нөхцөл байдлын үнэлгээ хийгдээгүй, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд хамруулах талаар төлөвлөгөө байхгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “4.1.1. “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг;” гэж заасан.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “4.1.6. “хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ” гэж **эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх**, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагааг;” гэж заасан.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг илрүүлэх арга хэмжээг хамтарсан багаас хэрэгжүүлж, ажилласан нь баримтаар нотлогдохгүй байна. Хүүхдийн эрх зөрчигдсөн тухай дуудлага, мэдээлэл ирсний дараа хамгааллын үйлчилгээг үзүүлж ажиллаж байна.

Аудитаар сум, багийн 13 хамтарсан багийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааг шалгахад дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Хамтарсан багийн нийгмийн ажилтнаар мэргэжлийн бус хүнийг томилсон,
- Кейсийн нууц хамгаалалт хангалтгүй, сэйф байхгүй,
- Санхүүгийн болон кейс бүрдэл дутуу, архивын хадгаламжийн нэгж болгоогүй,
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг гаргаж хүүхэд хамгааллын хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулаагүй,
- Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлсэн нь баримт материал дутуу.

Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхэд аймгийн хэмжээнд мэргэжлийн сэтгэл зүйч, хамтарсан багийн нийгмийн ажилтны хүний нөөц дутмаг, оролцогч талуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, хамтарсан багийн гишүүдийг урамшуулах хөшүүрэг сул зэрэг шалтгаанууд нь хүүхэд хамгааллын үйлчилгээг цогцоор нь үзүүлэхэд сөргөөр нөлөөлсөн байна.

Аудитаар хүүхдийн өмнө үүрэг хүлээсэн оролцогч талуудаас тоон мэдээлэл авахад зөрүүтэй байна.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрээгүй хүүхдийн тоо мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6

№	Холбогдох байгууллагууд	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	5	8	14	14	12
2	Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	-	-	-	13	12
3	Дорнод аймгийн Цагдаагийн газар	16	15	15	18	22
4	Дорнод аймгийн Эрүүл мэндийн газар	0	2	0	0	0

2.2.5 Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхдийн хувь хүний нууц алдагдах эрсдэл өндөр байна.

Хамтарсан багийн үйл ажиллагааны баримтын нууц хамгаалалт хангалтгүй байна. Сум, багийн хамтарсан багт очиж ажиллахад хүчирхийллийн хохирогчтой уулзах тусдаа өрөө байхгүй, кейсийн баримт материалыг үдэж цэгцлээгүй, зарим баг кейсийн баримт материалыг багийн ажлын албаны баримт материалтай хамт үдсэн. Кейс хадгалах тусдаа сейф байхгүй зэрэг зөрчил нийтлэг байна.

Энэ нь хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн мэдээлэл гадагш алдагдах эрсдэлтэй байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2017 оны А/116 дугаар тушаалаар “Түр хамгаалах байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”-ын 2.11 Түр хамгаалах байрны аюулгүй байдлын хамгаалалтыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35.6-д заасны дагуу **цагдаагийн байгууллага, эсхүл харуул хамгаалалтын байгууллагаар гүйцэтгүүлнэ.** гэсэн заалт хэрэгжихгүй байна.

Түр хамгаалах байрны зохион байгуулагч нь гэр бүлийн хамт тухайн объектод байрлан амьдарч хамгаалах байрны аюулгүй байдлыг хариуцаж байгаа нь хууль, журамтай нийцэхгүй байна.

2.2.6 Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг 2022 оноос урьдчилсан сэргийлэх ажил болон хариу үйлчилгээнд хуваарилж төсөвлөсөн байна.

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь 2019-2021 онуудад төсвийг урьдчилсан сэргийлэх ажил, хариу үйлчилгээнд гэж хуваарилж, төсөвлөж ажилладаггүй байсан байна. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газраас бөөн дүнгээр санхүүжилтийг олгож ажилласан байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар нь 2022 оноос эхлэн Шуурхай тусламжийн үйлчилгээ, Хүүхэд хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээ, Урьдчилсан сэргийлэх үйлчилгээ гэсэн ангиллаар санхүүжилтийг олгосон байна.

БҮЛЭГ 3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНГ ҮНЭЛЭЭГҮЙГЭЭС НИЙГЭМД ГАРЧ БУЙ ЭЕРЭГ НӨЛӨӨГ ТООЦОХГҮЙ БАЙНА.

3.1.1 Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлалгүйгээс хийгдсэн ажлын үр нөлөөг үнэлдэггүй байна.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын 2020 оны А/240 дугаартай тушаалаар батлагдсан “Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн элч, Хүүхдийн эрхийн ажилтны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал” байгаа ч оролцогч талуудын үйл ажиллагааг салбарын онцлогт нийцсэн шалгуур үзүүлэлт, аргачлалаар үнэлэхгүй байна.

Дорнод аймаг дахь Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж, дүгнэж ажиллаагүй байна.

Аудитаар салбар хоорондын уялдааг үнэлэх 8 асуулт бүхий санал асуулга бэлтгэн 13 хамтарсан багийн 23 гишүүдээс авч ажиллахад 52.2 хувь нь хамтарсан багийн гишүүдийн хоорондын уялдаа холбоо хангалтгүй гэсэн дүгнэлт өгсөн байна. Тухайлбал өрхийн эмч, багийн цагдаа нарын ажлын ачааллаас болж кейс бүрт хамтарч ажилладаггүй байна.

3.1.2 Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хуулийн хэрэгжилтийн талаарх судалгаа, хяналт шинжилгээ хангалттай хийгдээгүйгээс сайжруулах шаардлагатай хэсгийг тодорхойлж ажиллаагүй байна.

Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын даргын хамтарсан 2023 оны А/34, А/12 дугаартай тушаалаар “Нээлттэй хяналт-шалгалт хийх тухай” удирдамж батлагдсан байна. Нээлттэй хяналт-шалгалтыг аймгийн холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүд гүйцэтгэж аймгийн хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийн ерөнхий үнэлгээ 90.8 хувьтай үнэлэгдсэн байна.

Хяналт шалгалтыг аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын холбогдох мэргэжилтнүүд батлагдсан асуумжийн дагуу ярилцлага, санал асуулгад тулгуурлан үнэлгээг боловсруулж ажилласан тухай тайлагнасан байна.

Нээлттэй хяналт шалгалтад Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагаа, боловсрол, эрүүл мэнд, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Асрамж халамжийн төв, Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төв, Хамтарсан багийн үйл ажиллагаа, Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Хүүхдийн байцаагч, Хүүхдийн элчийн үйл ажиллагаа холбогдох хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжилт, гарсан үр дүнд нээлттэй хяналт шалгалт хийхээр аргачлалд заасан байна.

Хяналтыг хэрэгжүүлэхдээ шалгах хуудас, санал асуулгыг шалгагдагч байгууллагын мэргэжилтнүүд өөрсдөө бөглөж, үнэлж ажилласан нь шалгалтын дүн, үнэлгээ бодитой бус байх нөхцөл ажиглагдаж байна.

Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт боловсрол, шинжлэх ухааны мэргэжилтэн, Цагдаагийн газарт хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн цагдаагийн ахмад, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт сургалт, хүний нөөц, хэвлэл мэдээлэл дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, шинжээч нар нь дүгнэлт гаргаж ажилласан байна.

Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтийн талаар тогтмол, судалгаа шинжилгээ, хяналт-үнэлгээ хийдэггүй байна.

3.1.3 Олон Улсын байгууллагаас Засгийн газарт өгсөн зөвлөмжийг биелүүлдэггүйгээс хүүхэд хамгаалал хангалттай сайжрахгүй байх эрсдэл нөхцөлийг бий болгосон байна.

Хүүхдийн эрхийн конвенцын 5 дугаар тайлангаар Монгол Улсын Засгийн газарт дараах зөвлөмжийг өгсөн байна.

- Хурдан морь унаач хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгийн асуудал,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асуудал,
- Ядуурал болон алслагдмал газар, хөдөө нутаг, төв суурин газрын хүүхдүүдэд цэвэр усны хүртээмж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийн асуудал,
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн чадварлаг нийгмийн ажилтнуудыг нэмэгдүүлэх асуудал,
- Хүүхдийн хувийн эрх чөлөө, нууцын асуудал,

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь хүүхдийн эрхийн конвенцын 5 дугаар тайланд өгсөн зөвлөмжийн биелэлтийг гаргаж ХГБХХЕГ-т 2021 онд гаргаж хүргүүлсэн байна.

Хүүхдийн эрхийн конвенцын 5 дугаар тайлангаар өгсөн зөвлөмжүүд орон нутагт бүрэн хэрэгжээгүй байна. Үүнд:

24.a: Үндэсний хэмжээний хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх ажлыг нэн тэргүүнд шийдвэрлэж хүүхдүүдэд үр дүнтэй үйлчилгээ үзүүлж чадах мэргэшсэн чадварлаг нийгмийн ажилтнуудын тоог олноор нэмэгдүүлэх;

41.d: Хурдан морины уралдаанд оролцож байгаад хүндээр гэмтсэн амь насаа алдсан хүүхдүүдийн хэргийг мөрдөн шалгаж буруутай этгээдэд хариуцлага ноогдуулах;

41.e: Хурдан морины уралдаан гэх мэт аюултай, хортой хүүхдийн хөдөлмөрт хүүхдийг оролцуулдаг бизнес эрхэлж буй төрийн албан хаагчдын хувийн болон албаны ашиг

сонирхлын зөрчил гаргаж буй үйлдэлд арга хэмжээ авах, ийм үйлдэл гаргуулахгүй байхад чиглэсэн хээл хахуулийн эсрэг арга хэмжээнүүдийг авах.

3.1.4 Хүүхэд хамгааллын чиглэлээр Олон Улсын байгууллагаас хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнг тооцоогүйгээс хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээлэл гарахгүй байна.

Япон Улсын Хүүхдийн ивээх сан нь ЖАЙКА-ын дэмжлэгтэйгээр Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, түүний харьяа байгууллагуудтай хамтран “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” II төсөл 2018-2022 онд Дорнод аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр баг, Баян-Уул, Халхгол сумдад хэрэгжсэн байна.

Хүүхэд хамгааллын тухай хуульд зааснаар хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлсэн үйлчилгээ, түүний үр дүнг үнэлж, шалгах үүрэгтэй.

Гэвч аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт төслийн хүрээнд хамрагдагч сум, багт хэрхэн ажилласан талаарх тайлан, баримт материал байхгүй байна. Иймд “Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” II төслийн хүрээнд Дорнод аймгийн хэчнээн иргэнд хүрч, ямар үр дүн гарсан нь тодорхойгүй байна.

3.1.5 Бодлогын хэрэгжилтийг бодитой үнэлж тайлагнадаггүйгээс бодлого нь нийгэмд ямар үр нөлөө бий болгосныг тооцоогүй байна.

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайлан гаргаж ажилладаг байна. Энэ нь ЗГ-ын 2017 оны 89, 2020 оны 206 дугаар тушаалаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/121 дүгээр тушаалаар “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж, дүгнэх журам”-ын хүрээнд хяналт-шинжилгээ үнэлгээг хийж ажилласан байна.

Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд тусад нь хяналт-шинжилгээ үнэлгээг хийж ажилладаггүй байна.

3.1.6 Хүүхдэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалгүйгээс хэрэгжилт, үр нөлөөг үнэлээгүй байна.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор “Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг” батлагдсан байна. Үүнд: бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал тусгагдаагүй байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2017 оны А/121 дүгээр тушаалаар “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж, дүгнэх журам”, 2023 оны А/45 дугаартай тушаалаар “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын эрхлэх асуудлын хүрээний

харьяа байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал"-ыг хавсралтаар шинэчлэн баталсан байна.

Эдгээр хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалд хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийг үнэлэх шалгуур, аргачлалыг тусгаагүй байна.

3.1.7 Хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлснээр нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцож үнэлдэггүйгээс бодлогын үр нөлөөг тооцоолдоггүй байна.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг"-т хэрэгжилт, үр дүнг тооцох аргачлал тусгаагаагүй тул аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллаагүй байна.

Нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцож үнэлэх аргачлал байхгүй бөгөөд үйл ажиллагааны тайландаа хүүхэд хамгаалал, урьдчилсан сэргийлэх чиглэлээр хийсэн арга хэмжээнд хамрагдсан хүний тоогоор хүүхдийн эрх хамгааллын хууль эрх зүйн мэдлэг олгож ажилласнаар тайлагнасан байна.

3.2.1 Гэр бүлийн орчинд чиглэсэн урьдчилсан сэргийлэх арга хэмжээ, үйлчилгээ хангалтгүйгээс гэр бүлийн орчин дахь хүүхдийн хүчирхийллийн тоон үзүүлэлт буурахгүй байна.

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар болон Хэрлэн сумын 11 багийн хамтарсан багаас айл өрхүүдэд хүүхэд хамгааллын талаар сургалт, мэдээлэл, гарын авлага тараадаг боловч хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт гэр бүлийн орчинд нөлөөлж чадахгүй байна.

Монгол Улсын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан "Хүүхэд хамгааллын тухай" хуулийн 5 дугаар зүйлд зааснаар "Эцэг, эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээг авна" гэж заасан боловч эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь архины хамааралтай учраас гэр бүлийн орчинд хүүхдийг үл хайхрах болон бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэл давтан үйлдэгдсээр байна.

Гэр бүлийн орчинд хүүхэд хамгааллын бодлого хэрхэн нөлөөлж буйг тооцож үнэлэх аргачлал байхгүй байна.

Хүүхдийн тусламжийн 108 онлайн программаас авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд: Хүүхдийг үл хайхрах тохиолдол 2021 онд 35 хүүхэд, 2022 онд 62 хүүхэд, 2023 онд 76 хүүхэд байгаа нь хүүхэд хамгаалал гэр бүлийн орчинд нөлөөлөл хангалтгүй, тоон үзүүлэлт буурахгүй байна.

3.2.2 Боловсролын байгууллагууд хүүхэд хамгааллын бодлогыг үйл ажиллагаандаа баримтлан ажилласан байна.

Дорнод аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь “Хүүхэд хамгааллын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д зааснаар Хүүхэд хамгааллын талаар төлөвлөгөө хөтөлбөр боловсруулж, маягтын дагуу ерөнхий боловсролын сургуулиуд болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр авч ажилласан байна.

Мөн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг гаргаж Засаг даргын тамгын газарт болон Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газарт хүргүүлж ажилласан байна. Дорнод аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 26 сургуулийн 23 нь мэргэжлийн нийгмийн ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.

Хувийн хэвшлийн “Түгээмэл оюун”, “Долоодой”, “Flower” сургуулиудад мэргэжлийн нийгмийн ажилтан байхгүй байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хүүхэд хамгааллын ажлыг арга зүйч нар хийж гүйцэтгэдэг байна.

Сургалтын байгууллагад суралцаж байгаа хүүхэд бүрийг тухайн орчинд бие махбодын шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар ажлыг жил бүр зохион байгуулж ажилласан байна.


Жишээ нь : 2019-2023 оны хичээлийн жилийн байдлаар 1-р сургуулийн хэмжээнд хүчирхийлэлд өртөх нөхцөлд байгаа хүүхэд 2019-2021 онд 24 байсан бол 2022-2023 онд 15 болж буурсан байна.

3.2.3 Эрүүл мэндийн байгууллага нь төрийн бус байгууллагатай хамтарч хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлд “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага, албан тушаалтан, хувь хүнд мэдээлэхийг хориглох бөгөөд задруулснаас үүдэн гарах үр дагаврыг өөрөө хариуцна” гэж заасны дагуу Эрүүл мэндийн газрын Хүүхэд, өсвөр үе хариуцсан мэргэжилтэн Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газартай нууцын гэрээг байгуулсан байна.

Хүүхэд болон өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох үүднээс сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Ашид батжих” ТББ-тай гэрээ байгуулж “Аз жаргал” төвөөр дамжуулж, хүүхэд болон өсвөр үеийнхний бэлгийн боловсрол, нөхөн үржихүйн цогц боловсрол олгох, үе тэнгийн зөвлөх багш, өсвөр насны охидын жирэмслэлт, хүүхэд, өсвөр үеийнхэнд тулгамдаж буй асуудлыг шийдэх зэргээр хамтарч ажилласан байна.

“Аз жаргал” төв нь өсвөр насны охидын эрүүл мэндийн үзлэг хийх кабинетыг Дорнод аймгийн Эрүүл мэндийн газарт байгуулсан байна. Эрүүл мэндийн газраас өрхийн эмч нарт хүүхдийн эрүүл мэндийн талаар сургалт, мэдээлэл өгч ажилласан байна. Дээрх үйл ажиллагааг явуулснаар өсвөр насны охидын жирэмслэлт буурсан байна.



Эх сурвалж: ЭМГ-ын статистик мэдээ

3.2.4 Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалал хангагдахгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, багш, сургуулийн ажилтан сургуулийн орчинд, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд бусад орчинд өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом ном, урлагийн бүтээл, мэдээ, мэдээлэл зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаална” гэж заасан боловч дээрх заалт хэрэгжихгүй байна.

Шалтгаан нь хэвлэл мэдээлэл болон цахим орчинд хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөргөөр нөлөөлөхүйц тоглоом, зар сурталчилгаа хэвлэл мэдээлэл болон цахим орчинд гарч байгаатай холбоотой байна.

Эцэг, эх нь facebook, Instagram, youtube зэрэг платформд хаяг нээх нас нь хүрээгүй байхад хаяг нээж өгч байгаа нь хүүхдийг цахим орчинд ямарваа нэгэн хүчирхийлэл болон аюулд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Эдгээр платформуудад хүүхдүүдийн хүмүүжил, төлөвшил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээ мэдээлэл, зар сурталчилгаа, видео бичлэг, зургууд шүүлтүүргүй байна.

Мөн “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11-д “хүний хувийн мэдээлэл” гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол,

гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг” гэж заасан байна.

Эцэг, эх нь хүүхдийнхээ талаарх хувийн мэдээллийг өөрийн цахим хаягаар дамжуулан мэдээлж байгаа нь хүүхдийг эрсдэлд оруулах нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн олон нийтийн телевизүүд мэдээ, сурвалжилга бэлтгэхдээ хүүхдийн царай, овог нэр гаргаж хүүхдийн эрхийг зөрчиж байна.

Дээрхээс дүгнэхэд хэвлэл мэдээлэл болон цахим орчин дахь хүүхэд хамгаалал хангагдахгүй байна.

3.2.5 Олон нийтийн арга хэмжээ, соёл, спортын үйл ажиллагаанд хүүхэд хамгааллыг хангаж ажилласан байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар Соёл, спортын болон олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ дэх хүүхэд хамгааллыг Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар болон аймгийн Боловсролын газар, Биеийн тамир, спортын газар хамтын ажиллагаатай оролцож, хангаж ажилладаг байна.

Хүүхдүүдийг улс, орон нутгийн чанартай тэмцээн, уралдаанд оролцохоор авч явахдаа ХГБХХГ-аас мэдэгдэж, заавар зөвлөмж бичгээр авдаг байна.

Соёл, спортын арга хэмжээнд хамрагдсан хүүхдийн тоо дараах байдалтай байна.

Хүснэгт №7 /2019-2023 он/

№	Сургуулийн нэр	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	1-р сургууль	-	-	128	135	154
2	2-р сургууль	-	-	31	34	38
3	5-р сургууль	-	-	84	109	135
4	8-р сургууль	-	-	35	32	65
5	11-р сургууль	35	28	32	30	40
6	Долоодой сургууль	-	-	-	-	-
7	12-р сургууль	62	68	89	86	98
8	Хан-Уул	-	-	119	134	146
9	Шинэ хөгжил	-	-	35	48	69
10	Фловер	-	-	-	-	-
11	Түгээмэл оюун	-	-	10	10	-
12	Дорнод ахлах сургууль	-	-	-	-	-
13	Баяндун сумын ЕБС	64	83	120	172	180
14	Баянтүмэн сумын ЕБС	-	-	-	-	-
15	Баян-Уул сумын ЕБС	100	150	190	220	360
16	Булган сумын ЕБС	-	-	32	34	38
17	Гурванзагал сумын ЕБС	-	-	-	-	1
18	Дашбалбар сумын ЕБС	46	54	89	120	140
19	Матад сумын ЕБС	-	-	-	24	17
20	Сэргэлэн сумын ЕБС	-	-	-	-	-
21	Халхгол сумын ЕБС	-	-	-	-	-
22	Халхгол сумын Ялалт багийн сургууль	28	32	65	74	53

23	Хөлөнбуйр сумын ЕБС	89	96	108	132	114
24	Цагаан-Овоо сумын ЕБС	85	90	165	215	360
25	Чойбалсан сумын ЕБС	-	-	-	-	24
26	Чулуунхороот сумын ЕБС	96	96	116	90	94
	Нийт	605	697	1448	1699	2126

/Эх сурвалж: Дорнод аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар/

3.2.6 Аймгийн “Хүүхэд хамгааллын бодлого”-ын баримт бичигт гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгааллын асуудлыг тусгаагүй байна.

Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал MNS 6948:2021 стандартын 10.3.1 “Байгууллага бүр үйл ажиллагааны чиглэл, онцлогт нийцүүлэн хүүхэд хамгааллын бодлого, дүрмээ боловсруулахдаа гамшгийн үеийн хүүхэд хамгааллын асуудлыг тусгана.” гэж заасан.

Өмнөх Хүүхэд хамгааллын тухай хуульд гамшгийн үеийн хүүхэд хамгааллын асуудал тусгагдаагүй байсан байна. Харин 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн Хүүхэд хамгааллын шинэчилсэн хуулиар гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгааллыг оруулж баталсан байна.

Аймгийн “Хүүхэд хамгааллын бодлого”-ын баримт бичигт Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгааллыг оруулж батлах шаардлагатай байна.

3.3.1 Монгол Улс Хүүхдийн эрхийн олон улсын конвенцод нэгдсэн үүргийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл орон нутагт байхгүй байна.

НҮБ-ын “Хүүхдийн эрхийн конвенц” 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр батлагдсан. Манай Улсын хувьд 1990 оны 07 дугаар сарын 05-ны өдөр нэгдэн орсон байдаг.

Хүүхдийн эрхийн тухайн конвенцод хүүхэд гэж хэнийг хэлэх, тэд ямар эрх эдлэх, тэдгээр эрхийг хэрэгжүүлэхэд төр ямар үүрэгтэйг тайлбарласан байна.

“Хүүхдийн эрхийн конвенц”-оор хүлээсэн үүрэгтэй холбоотойгоор орон нутагт тайлан, баримт, мэдээлэл байхгүй байна.

3.3.2 Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, мөшгөх судалгаа хийгээгүй байна.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 595 дуудлага ирсэн байна. Дээрх хугацаанд ирсэн нийт дуудлагаас 44 дуудлагыг хуурамч дуудлага гэж хаасан байна.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагын жагсаалт /2019-2023 он/

Хүснэгт №8

№	Байгууллага болон сумдын нэрс	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	Нийт
1	ХГБХХГ	73	118	56	18	14	279
2	Баяндун сум	-	-	2	1	-	3

3	Баянтүмэн сум	-	-	1	3	2	6
4	Баян-Уул сум	-	-	1	4	1	6
5	Булган сум	-	-	1	-	-	1
6	Гурванзагал сум	-	-	-	3	2	5
7	Дашбалбар сум	-	-	-	4	-	4
8	Матад сум	-	-	-	2	4	6
9	Сэргэлэн сум	-	-	2	-	-	2
10	Халхгол сум	-	-	1	8	1	10
11	Хөлөнбуйр сум	-	-	-	3	1	4
12	Хэрлэн сум	-	-	56	99	98	253
13	Цагаан-Овоо сум	-	-	4	4	-	8
14	Чойбалсан сум	-	-	-	3	2	5
15	Чулуунхороот сум	-	-	2	1	-	3

/Эх сурвалж: Хүүхдийн тусламжийн 108 программ/

Хэрлэн сумын 11 багт Хүүхдийн тусламжийн 108 дугаарт ирсэн дуудлагын жагсаалт

Хүснэгт №9 /2019-2023 он/

№	Хэрлэн сум	2019 он	2020	2021	2022	2023	Нийт
1	1-р баг	-	-	6	15	9	30
2	2-р баг	-	-	7	12	9	28
3	3-р баг	-	-	3	9	4	16
4	4-р баг	-	-	6	4	10	20
5	5-р баг	-	-	1	1	2	4
6	6-р баг	-	-	9	22	21	52
7	7-р баг	-	-	2	6	9	17
8	8-р баг	-	-	1	-	4	5
9	9-р баг	-	-	10	7	10	27
10	10-р баг	-	-	7	11	10	28
11	11-р баг	-	-	4	12	10	26

/Эх сурвалж: Хүүхдийн тусламжийн 108 программ/

Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага /кейс/-ыг 108 онлайн программд 2019-2023 онд дараах байдлаар хаасан байна. Үүнд:

Нөхцөл байдлын үнэлгээ хийж оруулсан 173, нөхцөл байдлын үнэлгээ оруулаагүй 422, үйлчилгээ үзүүлсэн талаарх мэдээллийг оруулсан 159, үйлчилгээ үзүүлсэн талаар оруулаагүй 436, үйл явцын тэмдэглэл оруулсан 246, үйл явцын тэмдэглэл оруулаагүй 349 кейс байна.

Мөн 108 утсанд ирсэн зарим дуудлага, мэдээллийг хүлээн авч, нөхцөл байдлын үнэлгээг хөнгөн гэж үзэн хуурамч дуудлагаар бүртгэж хаасан тохиолдол цөөнгүй байна. Аудитын явцад Хэрлэн сумын 11 хамтарсан баг болон Булган, Хөлөнбуйр, Баянтүмэн зэрэг сумдын хамтарсан багийн 108 онлайн программд нэвтэрч үзэхэд дээрх зөрчлүүд нийтлэг илэрсэн.

Үүнээс дүгнэхэд хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн бүх дуудлага, мэдээлэлд стандартад заасны дагуу дүн шинжилгээ хийж, мөшгөх судалгаа хийж ажиллаагүй байна.

3.3.3 Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээг стандартад заасан хугацаанд түргэн шуурхай хүргээгүй байна.

Монгол Улсын Нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага /MNS 6949:2021/-ын 6.3.2.1-д: “Үйлчлүүлэгч аюултай нөхцөлд байгаа тухай шуурхай болон тусгай дугаарын утсанд ирсэн хяналт болон шуурхай дуудлагын үед аюулын зэргийг тогтоох, эрсдэлийн үнэлгээг хийх дуудлага авснаас хойш 24 цагийн дотор үнэлгээ хийнэ.”, “Нөхцөл байдлын үнэлгээг 72 цагийн дотор хийнэ” “Эрсдэлийн түвшингээр аюулын түвшин бага гэж тогтоогдсон тохиолдолд нөхцөл байдлыг үнэлгээг 3-5 хүртэлх өдрийн дотор хийнэ” гэж заасан.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд үзүүлэх хариу арга хэмжээг стандарт /MNS 6949:2021/-д заасан хугацаанд түргэн шуурхай хийж гүйцэтгээгүй байна.

Жишээ нь: Хэрлэн сумын 11 багийн хамтарсан багийн 2019-2023 онуудад Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага мэдээллийг шалгаж үзэхэд нийт 253 дуудлага, мэдээллээс 35 дуудлага мэдээлэл нөхцөл байдлын үнэлгээ хийгээгүй хаасан байна.

3.3.4 Аймгийн Цагдаагийн газраас хүүхдийн эсрэг гэмт хэргийн суурь шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллаж байгаа ч хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоо буурахгүй байна.

Хүүхдийн эсрэг гэмт хэргийн суурь шалтгаан, нөхцөлийг криминалистикийн судалгааны багаас авсан сар, улирлын дүн мэдээнд тулгуурлан гаргадаг байна.

Гэмт хэрэг, зөрчилд холбогдож байгаа шалтгаан нь эцэг, эх, асран хамгаалагчийн хараа хяналт сул, мөн эцэг, эх, асран хамгаалагч нь архины хамааралтай, сумдаас аймгийн төвд суралцаж байгаа хүүхдийн хараа хяналт сул байгаатай холбоотой байна.

Дорнод аймгийн Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх алба нь гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэн хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хүчирхийлэлгүй гэр бүл”, “Гэр бүлийн өдөр”, “Харилцан хүндэтгэе” зэрэг аян, иргэд, олон нийтэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тоон мэдээлэл мэдээлэх, иргэдээс санал асуулга авах, хэсгийн төлөөлөгч нарт хүүхэд хамгааллын талаар сургалт өгөх зэрэг ерөнхий болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажилласан байна.

Хүүхэд хамгааллын ерөнхий арга хэмжээний хүрээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах “Анхаарч хамгаалъя” аяныг өрнүүлж, эрсдэлт нөхцөлд амьдарч буй, хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүүхдийг илрүүлэх зорилгоор айл, өрхүүдээр явж хяналт шалгалт хийж ажилласан боловч хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоо буурахгүй байна.

Жишээ нь: Аймгийн Цагдаагийн газраас авсан тоон мэдээнээс харахад хүүхдийн эсрэг гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо 2019 оны байдлаар 17 байсан бол 2022 онд 32, 2023 онд 37 болж өссөн үзүүлэлттэй байна.

3.3.5 Хүүхэд хамгаалалтай холбоотой хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн хүчирхийллийн тоон үзүүлэлт дээр дүн шинжилгээ хийж, шалтгааныг тогтоож ажиллахгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуульд Гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь “нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаарх мэдээлэл, судалгаанд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлох”, “хууль зөрчсөн, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон хүүхдийн талаар бүртгэл, судалгааг цагдаагийн болон хууль сахиулах бусад байгууллагатай хамтран гаргаж, дүн шинжилгээ”-г хийнэ гэж заасан.

Аймгийн ХГБХХГ-аас Эрүүл мэнд, Боловсрол, Цагдаагийн газрын хүүхэд хамгаалалтай холбоотой статистик үзүүлэлтүүдийг нэгтгэж дүн шинжилгээ хийж, хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг тогтоож ажиллаагүй байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

 МОНГОЛ УЛС ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг Харлан сум, Дорнод аймаг, 21000 Утас: 7058-4202, факс: 7058-4584 Цахим шуудан: azdtg@dornod.gov.mn Цахим хуудас: Dornod.gov.mn	Г ДОРНОД АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА
2024.10.25 № 7/2024 танай _____ -ны № _____ -т	<i>Б.Ванширваг</i> <i>Маминцаг саналыг нэгтгэн орон саналд илгээх.</i> <i>Аудитын тайлан дүрсэн, Тайлан тушаалаар батлах.</i> <i>Б.Болортуул</i> 21/10/24
Г Санал хүргүүлэх тухай Г	
“Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангаар ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.	
Мөн Үндэсний аудитын газарт хүргүүлэх нэгдсэн тайланд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:	
Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын бүтэц нь Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын 2024 оны А/206 дугаар “Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын албан тушаалын нэршил, ангилал, зэрэглэл, бүтцийн зураглалыг батлах тухай” тушаалаар үндсэн 21 орон тоотойгоор батлагдсан бөгөөд тус бүтцэд мэргэжлийн сэтгэл зүйчийн орон тоо батлагдаагүй байна.	
Иймд аймгийн хэмжээнд хүүхэд, гэр бүлд сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн сэтгэл зүйчийн орон тоог аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын үндсэн бүтэц дээр нэмж тусгуулах саналыг хүргүүлж байна.	
 ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ш.ЁЛ	

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, хүүхдийн эрхийг хангах түр хамгаалах байрны хүрэлцээ муу, стандартын шаардлага хангахгүй байна.
 2. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийхгүй, зөвхөн хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийлэл гарсан тохиолдолд нөхцөл байдлын үнэлгээ хийж хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлж байна.
 3. Хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагааны мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүйгээс хүүхдийн эрх хамгийн их зөрчигдөж байгаа асуудалд бодлого боловсруулахад хүндрэл гарах эрсдэлтэй байна.
 4. ХГБХХГ-т хүүхэд хамгааллын мэргэжилтний орон тоо хүрэлцээгүй, мэргэшсэн албан хаагч цөөн, хамтарсан багийн нийгмийн ажилтнууд нь мэргэжлийн шаардлагыг хангахгүй байна.
 5. Хүүхэд хамгаалалд зориулсан төсөв, зардлыг судалгаанд үндэслэн тооцож төлөвлөөгүйгээс оновчтой хуваарилагдахгүй байна.
 6. Улс, орон нутгийн төсвөөс сум, багийн хамтарсан багуудад эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд нөхцөл байдлын үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ хийх зардлыг хуваарилж олгоогүй байна.
 7. Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтыг ил тод тайлагнахгүй байгаа нь батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах эрсдэлийг үүсгэж байна.
 8. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхдийн хувь хүний нууцыг хууль, журамд заасны дагуу хамгаалахгүй байгаа нь хүчирхийлэлд өртсөн хүүхдийн мэдээллийг олон нийтийн сүлжээ болон хэвлэл нийтлэлээр зөвшөөрөлгүй нийтлэн түгээх эрсдэлтэй байна.
 9. Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгаалал хангагдахгүй байна.
 10. Аймгийн “Хүүхэд хамгааллын бодлого”-ын баримт бичигт гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгааллын асуудлыг тусгаагүй байна.
 11. Хүүхдэд хамгааллын бодлогын хэрэгжилтийн тайлан, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалгүйгээс нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцож үнэлээгүй байна.
- Аудитаар 258.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 7 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 6 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүллээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх зардлыг орон нутагт хуваарилах.
2. Хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагааны мэдээллийн нэгдсэн сан үүсгэх.
3. Хүүхдийн эрхийн байцаагч, хүүхэд хамгааллын мэргэжилтэн аймаг, сум, багийн хэмжээнд хэдэн хүүхдэд хүрч ажиллах тухай стандарт тогтоох.
4. Хүүхэд хамгааллын төсвийн төслийг боловсруулах аргачлал боловсруулах.
5. Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчин дахь хүүхэд хамгааллын бодлого боловсруулах.
6. Хүүхэд хамгааллын бодлогын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал боловсруулж, нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцож үнэлж байх.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, хүүхдийн эрхийг хангах түр хамгаалах байрыг “Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 6040:2019 стандарт”-д нийцүүлэх ажлыг зохион байгуулах.
2. Аймгийн “Хүүхэд хамгааллын бодлого”-ын баримт бичигт гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгааллын асуудлыг тусгуулах.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт:

1. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхдийн хувь хүний нууцыг хамгаалж ажиллах.
2. Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, мөшгөх судалгааг хийж ажиллах.
3. Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээг стандартад заасан хугацаанд түргэн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах.
4. Хүүхэд хамгаалалтай холбоотой хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн хүчирхийллийн тоон үзүүлэлт дээр дүн шинжилгээ хийж, цаашид сайжруулах шаардлагатай асуудлыг тодорхойлж ажиллах.

5. Аймгийн хэмжээнд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

АЛБАН ШААРДЛАГА:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 01/45 ГНАГ-2024/40-ШТА-ГА

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.2 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2016 оны А/330 дугаар тушаалаар "Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам"-ын дагуу Дорнод аймагт "Бүхнийг хүүхдийн төлөө" ТББ, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо", "Аз жаргал төв" гэсэн 3 байгууллага магадлан итгэмжлэгдэж үйл ажиллагаагаа явуулсан байна. Эдгээр төрийн бус байгууллагатай байгуулсан гэрээ мөн хүүхэд хамгааллын зардлын хөрөнгө зарцуулах тухай байгууллагын даргын 2022 онд А/01 дүгээр тушаалаар 130.4 сая төгрөг, 2023 оны А/13 дугаар тушаалаар 37.8 сая төгрөг, 2023 оны А/14 дүгээр тушаал 79.0 сая төгрөгийн зарцуулах шийдвэрийг байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулж мэдээлээгүй байна.

2. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу санхүүжилтээ мэдээлэх үүрэгтэй. "Анна хоме" асрамж, халамжийн төвд 2023 онд нийт 11.0 сая төгрөгийн хувьсах зардлыг олгосон байна. "Анна хоме" асрамж, халамжийн төв нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэсгүйгээс авсан санхүүжилтээ мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.8 ..., **төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах**, өр, авлага үүсгэсэн аливаа **шийдвэр**; 6.9 Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв ... төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг ... санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах,..." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан

011041446

зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн...” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллаагүй дээрх зөрчлүүдийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Сайхангэрэлд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР

Б.БАТЖАРГАЛ



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/13

Чойбалсан хот

Г

Тайлан баталгаажуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг УАГ-ын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Батжаргалд даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010175

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны
10 дугаар сарын 25-ны өдрийн
10 дугаар тушаалын хавсралт

Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Албан шаардлагын дугаар	Албан шаардлагын дүн /сая.төг/
1	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	01/145 ГНАГ-2024/20-ШТА-ГА	258.2
Дүн			

Дорнод аймаг Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын
Тамгын газрын байр, 4 давхарт
Утас: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-мэйл: dornod@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn